

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН  
ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, САНАЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН  
2023 ОНЫ 1-Р УЛИРЛЫН МЭДЭЭ

2023.03.30

2023 оны 1-р улирлын байдлаар Засаг даргад 10, Засаг даргын Тамгын газарт 1, иргэний бүртгэлийн асуудлаар 93, нийт 104 өргөдөл хүлээн авч шийдвэрлэсэн.

Засаг дарга болон ЗДТГ-т нийт 104 өргөдөл ирсний 93 өргөдөл буюу 89,4 хувь нь иргэний бүртгэлтэй холбоотой асуудлаар, 11 өргөдөл буюу 10,6 хувь нь бусад өргөдөл эзэлж байна.

Засаг даргын Тамгын газарт иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, санал шийдвэрлэлтийн талаар авсан арга хэмжээ:

Нэг: Иргэний бүртгэлийн асуудлаар нийт 93 иргэний өргөдөл ирснийг хугацаанд нь шийдвэрлэсэн. Үүнд:

1. Шинэ төрсөн хүүхэд - 18
2. Гэрлэлт – 1
3. Нас баралт - 2
4. Иргэний үнэмлэхтэй холбоотой - 22
5. Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой – 28
6. Гадаад паспорт - 22

Хоёр: Бусад 11 өргөдөл ирсэн. Үүнд: Өмчлөлийн газрын талбайн хэмжээний зөрүүг арилгаж өгөх тухай 3 өргөдлийг Засаг даргын 2023 оны А/18, А/30, А/40 дугаар захирамжаар тус бүр шийдвэрлэсэн. Харгалзан дэмжигчээр тогтоох тухай 1 өргөдөлд 2023 оны А/39 дугаар захирамжаар харгалзан дэмжигчээр тогтоосон. Гэр хүссэн 1 өргөдөлд Засаг даргын 2023 оны 1/129 тоот албан бичгээр гэр олгох боломжгүй тухай хариуг өгсөн. Тэмцээн зохион байгуулахад дэмжлэг хүссэн 1 өргөдөлд Засаг даргын 2023 оны А/32 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс 331500 (гурван зуун гучин нэгэн мянга таван зуу) төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Нөлөөллийн бүсэд байгаа малчин өрхүүдэд дэмжлэг үзүүлэх тухай хүсэлт ирснийг Страто ХХК-д уламжилж өгсөн. Дэлгүүрийн ажиллах цагийн хуваарьт өөрчлөлт оруулж өгөхийг хүссэн 1 өргөдөлд Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1/99 тоот албан бичгээр хариуг өгсөн. Өвөлжөө, хаваржааны газар хүссэн 3 өргөдлийг газрын координатын цэгийг

тогтоож, сумын 2024 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусган Иргэдийн төлөөлөгчдийн хуралд уламжлахаар төлөвлөөд байна.

Хүснэгт №01

2023 оны 1-р улиралд иргэдээс сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт шийдвэрлэлтийн байдал

| № | Байгууллагын нэр          | Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо | Шийдвэрлэлт            |                               |                               |                  | Шийдвэрлэлт /хувь/ |
|---|---------------------------|--|------------------------|-------------------------------|-------------------------------|------------------|--------------------|
|   |                           |  | Шийдвэрлэж хариу өгсөн | Бусад байгууллагад шилжүүлсэн | Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн | Хугацаа болоогүй |                    |
| 1 | Засаг даргын Тамгын газар | 104  | 103                    | 1                             | -                             | -                |                    |
|   | Дүн                       | 104  | 103                    | 1                             | -                             | -                | 100                |

Хүснэгт №02

2023 оны 1-р улиралд иргэдээс сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт /хэлбэрээр/

| № | Байгууллагын нэр          | Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт | Үүнээс: |              |                 |        |                         |  |
|---|---------------------------|---|---------|--------------|-----------------|--------|-------------------------|--|
|   |                           |   | Бичгээр | 11-11 төвөөр | Цахим хэлбэрээр | Утсаар | Биечлэн уулзсан /амаар/ | Бусад /иргэдтэй ажиллах-Нээлттэй өдөрлөгөөр/ |
| 1 | Засаг даргын Тамгын газар | 104                                       | 104     | -            | -               | -      | -                       | -  |
|   | Дүн                       | 104                                       | 104     | -            | -               | -      | -                       | -  |

Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн агуулга /хувиар/  
/хэлбэрээр/

| № | Байгууллагын нэр          | Зонхилж байгаа асуудал<br>/тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/                              |
|---|---------------------------|--|
| 1 | Засаг даргын Тамгын газар | Нийт 104 өргөдлөөс:<br>- Иргэний бүртгэлтэй холбоотой 93 /89,4%/<br>- Бусад өргөдөл 11 /10,6%/ |

МЭДЭЭ ГАРГАСАН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Б.УУГАНБАЯР

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГА

П.ГАНЧИМЭГ

